



INTERNATIONAL ASSOCIATION FOR MONGOL STUDIES



ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТДИЙН Х ИХ ХУРЛЫН ИЛТГЭЛҮҮД
PROCEEDINGS OF THE 10th INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

**II БОТЬ
МОНГОЛ ХЭЛ, СОЁЛЫН
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

**VOLUME II
MONGOLIAN LANGUAGE AND CULTURE AND
THEIR URGENT PROBLEMS**

**Улаанбаатар хот
2012 он**

**II САЛБАР:
МОНГОЛ ХЭЛ, СОЁЛЫН
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

***SECTION II:
MONGOLIAN LANGUAGE AND CULTURE AND
THEIR URGENT PROBLEMS***

Салбар хуралдааны дарга: <i>Chairman of the Section:</i>	Академич Д.Төмөртоогоо (Монгол) <i>Academician D.Tumurtogoo (Mongolia)</i>
Салбар хуралдааны орлогч дарга: <i>Vice-chairman of the Section:</i>	Профессор Ш.Чоймаа (Монгол) <i>Professor Sh.Choimaa (Mongolia)</i>
Салбар хуралдааны эрдэмтэн нарийн бичгийн дарга: <i>Scientific Secretary of the Section:</i>	Доктор Э.Пүрэвжав (Монгол) <i>Doctor E.Purevjav (Mongolia)</i>

This Proceedings was prepared by the IAMS Secretariat

Editor-in-chief	Tumurtogoo D.
Executive Secretary	Purevjav E.
Technical Editor	Altantsetseg M, Battulga M.
Computer Typist	Narantuya Ch.

Editorial Address: Sukhbaatar Square-3
Ulaanbaatar-11, P.O. 20A
Mongolia

Office of the IAMS Secretariat
E-mail: iams@magicnet.mn
Phone/Fax: 976-11-261328
Phone: 976-11-262553, 262491

АГУУЛГА (CONTENTS)

Д.Төмөртөгөө. II салбар хуралдааны дүнгийн тухай сонсгол 5

МОНГОЛ ХЭЛЭЭРХ ИЛТГЭЛ

Амаржаргал Б (Монгол). Өрнөд Дорнод халхын зарим салбар аман аялгууг харьцуулсан судалгаа 6

Бадмаанямбуу Д (Монгол). Монгол хэлний хэмжээ илэрхийлэх зүй тогтол 9

Базаррагчаа М (Монгол). Эртний монгол хэлний үг бүтэх ёс 16

Байгальсайхан С (Монгол). “Толбо нуур” туужийн түүх - уран сайхны үнэнийг тодруулах асуудалд 23

Бат-Ирээдүй Ж (Монгол). Монгол хэлний тооны болон хэмт үгийн судалгааны асуудалд 26

Баянсан Ж (Монгол). Монгол хэлний хоршоо үгийн судлалын шинэ парадигмын зарим асуудал
(Хэлний сэтгэл судлал, хэлний соёл судлалын аспект) 28

Баярсайхан Б (ОХУ). Тува хэлний малын нэршлийг монгол хэлэнд харьцуулан судлах нь 30

Бенжамин Бросиг (Швед). Дундад зууны монгол хэлний байдал, эх үүсвэр, цагийн айн дүрэм 33

Билгүүдэй Г (Монгол). “Монголын нууц товчоо”-ны судлаачдын бий болгосон “шинэ домог” 38

Болд Л (Монгол). “Монголын нууц товчоо”-ны үгийн сангийн бүрэлдэхүүний асуудалд 41

Бүрнээ Д (Монгол). Үндэсний номын сангийн монгол бичмэл Ганжурын төгсгөлийн үгээс
орчуулагчийг тодруулах нь 45

Ван Мандуга (БНХАУ). С.Буяннэмэхийн намтар дахь зарим эндүүрлийг арилгах асуудалд 48

В.Зикмундова (Чех). Шинжааны шивээчүүдийн ад өвчин заслага монгол андайтай
холбогдох тухай 53

Галбаатар Д (Монгол). Социалист реализм ба системийн хандлага 57

Галбаяр Г (Монгол). “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир” зохиолын утга
санааны зарим онцлог 63

Галсан С (Монгол). XXI зууны хэл шинжлэлийн хандлага 69

Даваадагва Б (БНХАУ). Монгол хэл зүйн судлал дахь нэгэн онолын асуудал 71

Дулам С (Монгол). Харь гаралтай үлгэр домгийн идээшихэд архетипийн нөлөө: энэтхэг - төвд -
монгол домог зүйн жишээн дээр 74

Заяабаатар Д (Монгол). Хэвийн бүтээврийн түүхэн хувьслыг судлах асуудалд 82

И Сонг-Гюү (БНСУ). Солонгос хэлтэй хамаарал бүхий хятан хэлний үгсийн тухай 87

Ийда Жүн (Япон). Монгол хэлний үйл үгийн нөхцөл “-нэ, -в, -лээ, -жээ”-гийн зохиомжлох
байгуулалтын тухай 89

Ким Ки Сонь (БНСУ). Монгол ба Солонгосын зүйр цэцэн үгэнд гарч буй өнгөний бэлгэдэл ба
хэлний тоглоомын харьцуулсан судалгаа 91

Китамура Акихидэ (Япон). “Авав” гэдэг үйл үгийн хэлбэрийн хэрэглэгддэг давтамжийг тоолсон нь. 96

Лувсандорж Ж (Монгол). “Монголын нууц товчоо”-ны хятад галиг, мин хадмал ба европын
хэлнүүдийн орчуулгын тухай 98

Мако Фүжий (Япон). “Монголын Нууц Товчоо”-ны нэгдүгээр биеийн төлөөний үгийн олон тоонд
нуугдсан учир шалтгааныг шинжлэх нь 105

Мансан (БНХАУ). Монгол үндэстэн: “Мангол-Монгол” хэмээх нэрийдэл 108

Мөөмөө С (Монгол). Фонемийн онолын шинэ нээлтийн асуудалд 115

Окада К (Япон). Цэндийн Дамдинсүрэн ба социалист модернизаци 116

Оюунбадрах Д (Монгол). Монголын хүүхдийн уран зохиолд орчуулгын зохиолын үзүүлсэн нөлөө 119

Өнөрбаян Ц (Монгол). Монгол хэлэнд туссан хийсвэр (дотоод) ертөнцийн дүр зураг. 124

Пүрэв-Очир Б, Баасанбат Д (Монгол). Монгол хэлний “нам” хэмээх үгийн учир, утгын өргөсөл,
хэрэглээний эргэн тойрон 131

Равдан Э (Монгол). Монголын газар нутгийн нэрийн хэлбэр - утга зүйн хэв шинжийн судалгааны үр дүн 136

Ринчиндорж (БНХАУ). Монгол баатарлаг туулийн үүсэл хөгжлийн тухай 140

Самбуудорж О (Монгол). Монгол ярианы хэлний төвшний асуудалд 159

Саруул-Эрдэнэ М (Монгол). Орчин цагийн халх монгол хэл нь хүн ба хүн бусын хэл зүйн айтай болох нь. 163

Содбаатар (БНХАУ). Монгол хэлний зарим үйл үг бүтээх дагаврын үүсэл гарлын асуудалд 167

Соёлмаа (БНХАУ). Миний цуглуулсан вагиндара үсгийн сурвалжис 182

Сундуева Е.В (ОХУ). Монгол хэлнүүд дэх язгуурын (R) үсгийн аргаар мэдрэн хүртэхийг илэрхийлэх 195

Сүмбэрбат (БНХАУ). Монгол хэлний шинэ үгс хийгээд нийгмийн амьдрал 197

Үмэтани Хироюки (Япон). Монгол хэлний нэр үг, эс тусах үйл үг хоёроос бүрэлдсэн хэллэгүүдийн
зарим онцлог. 200

Хабунова Е.Э (ОХУ). “Жангар” туулийн уламжлал шинэ цагт 202

Хашимото М (Япон). МНТ-ны хамгийн сүүлийн зүйл дээр гарах газрын нэр Šilginčeg - ийн тухай 205

Хишигтогтох (БНХАУ). Монгол ордны дууны эх бичгийн судлал 207

Хөвсгөл С (Монгол). “Саран хөхөөний намтар” жүжгийн эх бичгийн тухайд 218

Хөгжих (БНХАУ). Монгол зүйр цэцэн үгэнд ноён нохой хоёрыг адилтган өгүүлсэн нь 222

Цолоо Ж (Монгол). Монгол туулийн баатрын орон гэр, оромж ба түүний нэр томъёо, бэлгэдэл 227

Цэрэнсодном Д (Монгол). Монгол туулийн судлалын шинэ хандлага 231

Цэцэнцогт (<i>БНХАУ</i>). Монгол хэлний үйл үгийн хэвийн онцлогийн тухай өгүүлэх нь	235
Чойжи (<i>БНХАУ</i>). Төвд sa-skya Dongub ба түүний монгол орчуулга	247
Чоймаа Ш (<i>Монгол</i>). “Монголын Нууц Товчоо”- ны хэлний судалгааг эрхэмлэх нь	253
Чулуунбаатар Л (<i>Монгол</i>). Монгол үгийн энерги	262
Чулуундорж Б (<i>Монгол</i>). Хэл шинжлэл: шинэлэг хандлага	266
Шибаяма Ю (<i>Япон</i>). Монголын уран зохиолын дахин мандалт	270
Ямада Юүхэй (<i>Япон</i>). Монгол төрөл хэлний зүүн зах - дагуур хэл түнгүүс төрөл хэлээс автагдсан нөлөө нь	273
Ямакоши Ясүхиро (<i>Япон</i>). Хамниган монгол хэлний эзэмшигч илрүүлэх арга	277

ДОКЛАДЫ НА РУССКОМ ЯЗЫКЕ

Бадмаева Л.Б (<i>Россия</i>). Сложные синтаксические комплексы бурятских летописных текстов.	285
Базарова В.В (<i>Россия</i>). Унификация письменности монгольского пространства в 1920-ые годы.	289
Гедеева Д.Б (<i>Россия</i>). О падежных показателях в языке письменного памятника “Зинзилинские постановления”	292
Герасимович Л.К (<i>Россия</i>). Некоторые особенности в лирической прозы Д.Батбаяра	296
Дашибалова Д.В (<i>Россия</i>). Научное наследие Н.Н.Поппе: неизвестные архивные материалы.	301
Донгак А.С (<i>Россия</i>). Монголоязычный фольклор жителей юго - восточной Тувы	304
Донгак У.А (<i>Россия</i>). Первые оригинальные сочинения Тувинской литературы 1920-30-х годов на старомонгольском письменном языке	310
Ефимова Л.С (<i>Россия</i>). Монгольские параллели в языке хороводных песен якутов	313
Кормушин И.В (<i>Россия</i>). К этимологии монгольского названия числительного “десять”.	317
Орус-оол С.М (<i>Россия</i>). Тувинский и Монгольский эпос в сравнительный освещении	321
Петрова М.П (<i>Россия</i>). Модернизм в Монгольской литературе начала XXI в.	324
Пюрбеев Г.Ц (<i>Россия</i>). Фразеология памятника Монгольского права XVIII в “Халха Джирум”	329
Раднаев В.Э (<i>Россия</i>). Синтез восточных и западных составных частей в монгольской лексикографии (XIV-XIX вв.)	333
Рассадин В.И (<i>Россия</i>). О системе наклонений глагола в монгольских языках	335
Рыкин П.О (<i>Россия</i>). К вопросу принципх китайской транскрипции монгольской лексики в китайско-монгольском словаре Дада юй / бэйлу июй (конец XVI–начало XVII в.)	339
Тагарова Т.Б (<i>Россия</i>). Стилистические функции синонимии фразеологизмов монгольских языков в художественной литературе	349
Трофимова С.М (<i>Россия</i>). О статусе категории определённости-неопределённости в монгольских языках.	352
Чимитдоржиева Г.Н (<i>Россия</i>). Морфологические и семантические характеристики монгольских заимствований в эвенкийском языке	356

PAPERS IN ENGLISH

Ekaterina Sobkovyak (<i>Switzerland</i>). Mongolian Translations of the Prätimoksa Sūtra and Changes in the Transmission of the Special Buddhist Terminology	362
Johnny Baltzeren (<i>Denmark</i>). Mongolise or Westernise (International Collaboration in Educational Change)	375
Koichi H (<i>Japan</i>). Mongolian Translations of Rātnajali; Their Significance in View of Philology and Linguistics	382
Maria Magdolna Tatar (<i>Norway</i>). The Agrarian Terminology of Turkic and Iranian Origin in Western Mongolian Dialects	388
Nariko Yamaguchi (<i>Japan</i>). Loanwords from Sanskrit in Mongolian Buddhist Scriptures— Focusing on Chapter XXI of the Lalitavistara.	394
Natalia Yampolskaya (<i>Switzerland</i>). A Rare Mongolian Translation of the Aṣṭasāhasrikā Prajāpāramitā Sutra	404
Purevjav E (<i>Mongolia</i>). Dictionary of Mongolian in the “Secret History of the Mongols”	407
Yakhontova N.S (<i>Russia</i>). Some texts claiming to be from “The sutra of Golden Light”	409
Yoko Kobayashi (<i>Japan</i>). A preliminary study of Language changes of Mongolian in Inner Mongolia caused by Language contacts with Chinese	412
Woo Sil Ha (<i>Korea</i>). Mongolian Culture and “The World View of Trichotomy (1-3-9-81)” - III: Focusing on Mongolian Folklore	420

ХАМНИГАН МОНГОЛ ХЭЛНИЙ ЭЗЭМШИГЧ ИЛРҮҮЛЭХ АРГА

Ямакоши Ясүхиро (Япон)

Өвөр Монголын Хуучин Барга Хошуунд амьдардаг Хамниганууд (Тэд өөрийгөө “камниган” гэж дууддаг)¹ нь хамниган монгол хэл (монгол хэлний хамниган аман аялгуу)-г хэрэглэдэг байна. Хамниган монгол хэлний авиазүй, хэлзүй бол орчин цагийн монгол хэлнээс ч, буриад хэлнээс ч ялгаатай. Жишээлбэл:

Мон. *Čii x'atd-aar jar^ɣ-x oo?*

Бур. *Šii x'atd-aar jar^ɣ-xa gša?*

Хам. *Čii kitad-aar jari-ku-či-gu?* г.м.

Хамниган монгол хэлээр “Эзэмшигч” болон “Эзэмшүүлэгч” хоёрын харьцааг гурван янзын аргаар илрүүлдэг юм. Тэр гурван арга гэдэг нь

1. харьяалахын тийн ялгал (ХТЯ)-аар илрүүлэх арга (үүнийг **D type** гэж нэрлэнэ),
2. гурван биед хамаатуулах (ГБХ) ёсоор илрүүлэх арга (үүнийг **H' type** гэж нэрлэнэ),
3. ХТЯ болоод ГБХ ёс хоёроор илрүүлэх арга (үүнийг **DH type** гэж нэрлэнэ)

болно. Монгол хэл ба буриад хэлэнд бас энэ гурван аргаар илрүүлнэ. Харин хамниган монгол хэлэнд **DH type**-ийг маш их хэрэглэдэг. Жишээлбэл:

Мон. *En čin' minii ax-iin jum.*

Бур. *Ene šni minii axai-n juumen.*

Хам. *Enə čini minii akaa-g-ai mni juumən.* г.м.

Ийм байдлаас гадна би энэ илтгэлд

а. Хамниган монгол хэлэнд “alienability” (хүний эзэмшлийг өөр хүнд өгч болно / болохгүй гэдгийг ялгах чанар)-ыг ГБХ ёсоор ялгадаг,

б. Манж-Тунгус төрөл хэлнүүдийн нөлөөгөөр ийм ялгах шинжтэй болсон магадгүй

гэдгийн тухай ярих гэж бодож байна.

1. “Эзэмшигч-эзэмшүүлэгч”-ийн харьцааг илрүүлэх дөрвөн хэлбэр

Nichols (1986)-ийн жишээн дэх [*head-marking / dependent-marking*]-ийн талаар Хамниган монгол хэл болон түүний хөрш хэлнүүдэд эзэмшигч - эзэмшүүлэгчийн харьцааг яаж илрүүлж байхыг тодруулбал, дараахь жишээ (1)-д үзүүлсэн мэтээр дөрвөн хэлбэрээр ялган хувааж болно. **H type** бол Сибирийн эвэнки хэлний жишээ, өөр гурван хэлбэрийн жишээ нь бүр хамниган монгол хэлнээс авсан байна.

(1) Эзэмшигч=*D(ependent)*; Эзэмшүүлэгч=*H(ead)*

Double-marking type (**DH type**): **D+pssr# H+pers**

akaa-g-ai *juumən=ni*

elder.brother-e-**gen** thing=**3:poss**

“my elder brother’s article”

Head-marking type (**H type**): **D#H+pers**

ollomimni *d'aw-in*

fisherman boat=**3sg:poss**

“the fisherman’s boat”

H type without **D (H' type)**: **H+pers**

tarikin=mini

head=**1sg:poss**

“my head”

Dependent-marking type (**D type**): **D+pssr#H**

minii *dəbtər*

1sg:**gen** notebook

“my notebook”

Үүнээс гадна, ХТЯ-ын дагаврыг ч нэмэхгүй, биед хамаатуулах үг ч үгүйгээр хоёр үгийг холбосон хоршоо үг мэт хэлбэрийг “*non-marking type*” гэж типологийн талаар Nichols (1986) зөвшөөрөж байна. Гэтэл ийм хоршоо үгнүүдийн дотор эзэмшигч-эзэмшүүлэгчийн харьцааг үзүүлэх жишээ байхгүй болсон мөртөө, манж-тунгус төрөл хэлнүүдэд бас ийм жишээ ховор гэж Цүмагари (1992: 246) хэлж байна. Ийм учраас энэ илтгэлд *non-marking type*-ийг жишээнээс хасаад, **DH type**, **H type**, **H' type**, **D type**-ын дөрвөн хэлбэрийг анхааран үзэх болно. Гэвч монгол төрөл хэлнүүдэд **H type** байхгүй учраас хамниган монгол хэл, буриад хэл, монгол хэл гурвыг үзэхдээ **D**, **H'**, **DH type** гурваар ялгана.

Үүнээс гадна, хоёрдугаар ба гуравдугаар биед хамаатуулах “*чинь*” “*тань*” ба “*нь*”-гийн дотор эзэмшигч буюу хамаатай биеийг заахгүй, зөвхөн өгүүлбэрийн гол гишүүн өгүүлэгдэхүүний илтгэцийн чадамжтайгаар

хэрэглэгдэх нь цөөнгүй байна. Жишээ нь:

- (2) Мон. *manai* *ols=čin'* *bur* *bajan* *bol-čix-ĵee*.
 1pl:gen country=2sg:poss perfectly rich become-pfv-pst
 “Our country has become rich.”

Ийм жишээг ч бас тооцохгүй.

2. Хамниган монгол хэлний эзэмшигч илрүүлэх арга

Хамниган монгол хэлний эзэмшигч илрүүлэх аргыг *D*, *H'*, *DH type* гурваар ялгаж болно. Жишээ нь:

- (3) *ХaM*. *D* *H'* *DH*
miniü *däbtär*. *tarikın=mini. miniü akaa=mini.*
 1sg:gen notebook head=1sg:poss 1sg:gen elder.brother=1sg:poss
 “my notebook” “my head” “my elder brother”

- (4) *ХaM*. *D* *DH*
takien-ii undugun. akaa-g-ai juumән=ni.
hen-gen egg elder.brother-e-gen thing=3:poss
 “a hen’s egg” “my brother’s stuff”

Энэ гурван хэлбэр нь аль хир хэрэглэгдэж байхыг шалгах аар Ямакоши (2007a)-аас жишээ авсан юм. Ямакоши (2007a) бол 1980-аад оноор Өвөр Монголын Их Сургуулийн судлаачдын БНХАУ-ын доторх монгол төрөл хэлнүүдийг байцаахад хэрэглэсэн өдөр тутмын ярианы материалыг хэрэглэн 2002 онд бичлэг хийсэн материал юм. Энэ материалын дотор гурван хэлбэр хэдий хэрэглэгдэж байсан гэдгийг дараах хүснэгтэд үзэх үү. Үүнээс гадна, (2)-дугаар жишээ үзүүлсэн мэтээр эзэмшигчийг заахгүй ГБХ үгийн жишээ нь нийт 30 (“*čini*”: *H'* *type*-д 20 жишээ, “*ni*”: *H'* *type*-д 9 жишээ, *DH type*-д 1 жишээ) байсан. Гэтэл монгол хэл шиг ХТЯ ба хамаатуулах үг хоёрын гурван бие нь зохьцохгүй жишээ ((2)-дугаарын *манай улс чинь* г.м.) нь нэг ч байхгүй байсан.

г.б.	<i>D</i>				<i>H'</i>				<i>DH</i>				нийт			
	1sg	1pl	2sg	2pl	sg	pl	sg	pl	sg	pl	sg	pl				
тоо											9		1	78		
	6		3	3	4	2		7	1	8	4	3	8	14,1	9,0	100
нийт	9				28				41				78			
%	11,5				35,9				52,6				100			

Хүснэгт-1. Хамниган монгол хэл

Хүснэгт1-ээс хархад *D type*-аас *H'* юм уу *DH type*-ийг илүү их хэрэглэж байна гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, эзэмшигчийг ГБХ ёсоор илрүүлэх заншилтай юм байна.

Үүний зэрэгцээгээр, ямар нэр үг нь эзэмшүүлэгчээр хэрэглэгдэж байгааг лавлаж үзлээ. Түүнийг (5)-д үзүүлье.

(5)

D: VI. *undugu* “egg”

VII. *däbtär* “notebook,” *tämdägläl-äi däbtär* “diary,” *zakidal* “letter”,
urtä “station,” *boroo* “mistake,” *зэсээ* “within”

H': I. *bäjән* “body,” *zurkin* “heart,” *tarikın* “head,” *gar* “hand,” *cirai* “face”

II. *ubcin* “sickness,” *noir* “sleepiness,” *ner* “name,” *naxon* “age”

III. *kobcaxon* “cloth,” *malagai* “hat,” *colkin* “socks,” *umdән* “trousers”

IV. *aba* “father,” *әzii* “mother,” *akaa* “elder brother”

VII. *azil* “job,” *nukur* “friend,” *әжкә* (psn), *juumән* “thing”

DH: I. *gar* “hand,” *niur* “face,” *tarikın* “head”

II. *käl* “language,” *turhән on sar* “birthday”

III. *cag* “watch,” *malagai* “hat”

IV. *aba* “father,” *akaa* “elder brother,” *әгәci* “elder sister,” *duu* “younger sibling,”

bacagan duu “younger sister,” *xamgan* “wife,” *kubuun* “son,” *kuu* “son,”

kuugäd “child,” *aci kubuun* “grandson”

VII. *gär* “house,” *turhән gazar* “hometown,” *kursi ailnood* “neighborhood,”

juumән “thing,” *ordән* “palace,” *әmnälgә* “hospital,” *orda* “in front of”

(5)-дугаар жишээнд заасан I-ээс VII гэдэг нь эзэмшүүлэгчийг бусад хүнд өгч чадах / чадахгүй (болох / болохгүй) гэдэг чанар (*alienability*)-аар ялгаж шатлан захирах ёсоор (*possession cline*) үзүүлсэн Tsunoda (1995: 576)-гийн судалгааны дагуу ангилан хуваасан зүйл болно. Tsunoda (1995: 576)-гаар энэ *possession cline* гэдэг нь дэлхийн хэлнүүдийн универсал (language universal)-ын нэг гэж хэлж байна. Tsunoda (1995: 576) эзэмшүүлэгчийг доорх заасан 7 ангид хувааж байна.

- I. биеийн нэг хэсэг (*толгой, гар, хөл, ам, хамар*, г.м.)
- II. биеийн байдал буюу биеийн шинж (*өвчин, эрүүл, нойр, нэр, нас*, г.м.)
- III. хувцас хунар ба чимэглэл (*дээл, гутал, малгай, хавчдаг ээмэг*, г.м.)
- IV. төрөл садан (*аав, ээж, хүү, охин, ах, дүү*, г.м.)
- V. тэжээдэг амьтан (*нохой, муур, таван хушуу мал*, г.м.)
- VI. эзэмшигчийн зохион бүтээсэн эд (*зураг, дуу, судлал*, г.м.)
- VII. өөр эднүүд

Шаталсан захиралын дээд ангид орох нэр үг нь эзэмшигч бусад хүнд өгч чадахгүй (эсвэл болохгүй) чанар хүчтэй байж, доод анги руу буурах тутам тийм чанаргүй болох гэнэ. VII ангид багтах нэр үгс нь ердөө бусдад хамаагүй өгч чаддаг юмнүүд гэж хэлж болно.

Энэ *possession cline*-гийн ёсоор үзвэл, ГБХ үгтэй *H' type* ба *DH type* хоёрын хооронд тодорхой ялгаа байхгүй гэж хэлж болно. Адил ангид багтах нэр үг (жишээлбэл *aba*) нь заримдаа *H' type*-аар, заримдаа *DH type*-аар эзэмшигч илрүүлж байна. Үүнээс гадна, *H' type* ба *DH type* хоёроор илэрхийлэгдэх эзэмшүүлэгч нэр үгсийн олонхи нь *possession cline*-гийн дээд ангид багтана. Харин *D type* бол тийм биш. Бусад хүнд өгч болохгүй чанартай нэр үгс эзэмшүүлэгч болоход *D type* хэрэглэгдэхгүй шиг харагдана. *H' type* ба *DH type* хоёрын жишээний дотор ч VII ангид багтах нэр үг байна. Гэвч ийм нэр үг ч гэсэн “*гэр*,” “*ажил*,” “*нөхөр*” гэх мэтээр эзэмшигчтэй ойр, бусдад өгч болохгүй гэж эзэмшигч бодож магадгүй юмнүүд гэж хэлж болно. Ингэж бодвол, бусдад өгч болохгүй эзэмшүүлэгчийг илрүүлэхэд ГБХ үг хэрэглэж, бусдад өгч болох эзэмшүүлэгчийг илрүүлэхэд ХТЯ-ыг хэрэглэдэг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, ГБХ үгтэй бол өгч болохгүй, ГБХ үггүй бол өгч болно. Ингэхэд (5)-д үзүүлсэн доороо зураастай нэр үгийн эзэмшигч нь хүн биш байгаа жишээ юм. Ийм үгнүүд нь *possession cline*-тай харьцаа байхгүй юм шиг харагдана.

Үүнийг хураангуйлбал:

- (6) а. *D type*-аас *H' type* ба *DH type* илүү их хэрэглэгдэж байна.
- б. ГБХ үгтэй/үггүй нь “*alienability*”-тай харьцаатай ч магадгүй

3. Хөрш зэргэлдээ монгол төрөл хэлнүүдийн байдал

Тэгвэл, одоо хөрш зэргэлдээ монгол төрөл хэлнүүдийн байдлыг үзье.

3.1 Буриад хэл

Хамниганууд хуучин үеээс буриадуудтай ихээр харьцаатай байсан. Тэдний өмсөх дээл (дэгэл) буриадын дээлтэй ялгаагүй. Бас Хятад дахь Хамниганууд бол Оросын Октябрын хувьсгал болход Агын Буриадуудтай цугтаа хил давсан гэсэн түүхтэй. Ийм болохоор буриад хэлний байдлыг ч анхааран үзэх ёстой.

Хамниган монгол хэлний байдлыг харахаар, өдөр тутмын ярианы материалаар буриад монгол хэлний ярианы жишээг түүсэн Ямакоши (2006)-аас жишээ авсан. Дараах хүснэгтэд үзэх үү.

г.б.	<i>D</i>					<i>H'</i>					<i>DH</i>					нийт
	1sg	1pl	2sg	2pl	3	1sg	1pl	2sg	2pl	3	1sg	1pl	2sg	2pl	3	
тоо	12	0	1	0	22	16	0	2	0	8	2	0	7	0	3	73
%	16,4	0	1,4	0	30,1	21,9	0	2,7	0	11,0	2,7	0	9,6	0	4,1	100
нийт	35					26					12					73
%	47,9					35,6					16,4					100

Хүснэгт-2. Буриад хэл

Хүснэгт 2-ыг үзвэл, хамниган монгол хэлнээс ХТЯ хэрэглэх *D type* (ХТЯ-аар илрүүлэх арга) их хэрэглэгдэж байна. Дараа нь ямар нэр үг эзэмшүүлэгчээр хэрэглэгдэж байхыг лавлаж үзсэн. Түүнийг (7)-д үзүүлье.

(7)

- D*: I. *gar* “hand,” *šarai* “face”
 II. *ner* “name,” *xaloon* “body temperature”
 III. *sag* “watch”
 IV. *aba* “father,” *ežii* “mother,” *axai* “elder brother,” *abžaa* “elder sister,”
xubuun “son,” *xuugeduud* “children”
 VII. *ažal* “work,” *nom* “book,” *temdegel-ei debter* “diary,” *zax'dal* “letter,”
boroo “mistake,” *xun emnelge* “hospital,” *urtəə* “station,” *tam'x'a* “cigarette,”
teŋgeri “weather,” *uildber* “factory,” *зосгоо* “within”
H': I. *bije* “body,” *zurxen* “heart,” *tar'x'an* “head,” *n'uur gar* “face and hand,” *šarai* “face”
 II. *nahan* “age,”
 III. *xobsahan* “cloth”
 IV. *aba* “father,” *axai* “elder brother,” *duu* “younger sibling,”
basgan duu “younger sister,” *xubuun* “son”
 VII. *ažal* “work,” *tergen* “wagon,” *zax'dal* “letter,” *sai* “tea,” *munөөder* “today,”

zarim “some of them”

DH: II. *janza* “appearance,” *unge* “color”

III. *xobsahan* “cloth,” *sag* “watch”

IV. *axai* “elder brother,” *abzaa* “elder sister,” *hamgan* “wife,” *aša* “grandson,”
duu basgan “daughter,” *xiugeduud* “children”

VII. *tooto* “homeland,” *xuršenuud* “neighborhood,” *zarim* “some of them”

(7) - дугаарын жишээнүүдээс үзэхэд хамниган монгол хэл шиг *alienable* / *inalienable*-ийг ялгаж байна гэмээр харагдахгүй. Иймээс буриад хэлэнд ГБХ ёс нь *alienable* / *inalienable*-тай харьцаагүй гэж хэлж болно.

(8) а. *D type*-ийг их хэрэглэдэг мөртөө, *DH type*-ийг ч бас хэрэглэнэ.

б. ГБХ ёс нь *alienability*-тай харьцаагүй

3.2 Орчин цагийн монгол хэл (халхын аман аялгуу)

Дараа нь орчин цагийн монгол хэлний байдлыг үзье. Жишээг Б.Чимэнбат (2002) орчуулсан О.Генригийн түүвэр зохиолын 10 үлгэрээс түүсэн. Харин хэвшмэл хэллэг, нийлэмж үг нилээд их хэмжээнд хэрэглэгдэх байсан тул эзэмшигч-эзэмшүүлэгчийн харьцаа болж байгаа / байхгүй гэдгийг ялгахад хэцүү болохоор гуравдугаар биеийн жишээг хасаад, нэгдүгээр, хоёрдугаар биеийн жишээг л түүсэн юм.

Хүснэгт 3-ыг үзвэл буриад хэл шиг *D type* (ХТЯ-аар илрүүлэх арга) их хэрэглэгдэж байна гэж хэлж болно. Тэгээд *DH type* (ХТЯ болон ГБХ ёс хоёроор илрүүлэх арга)-ны жишээ ховор байна.

г.б.	D				H'				DH				нийт
	1sg	1pl	2sg	2pl	1sg	1pl	2sg	2pl	1sg	1pl	2sg	2pl	
тоо	59	7	6	7	42	3	9	1	0	0	1	0	135
%	43,7	5,2	4,4	5,2	31,1	2,2	6,7	0,7	0	0	0,7	0	100
нийт	79				55				1				135
%	58,5				40,7				0,7				100

Хүснэгт-3. Орчин цагийн монгол хэл

(9)

D: I. *us* “hair,” *am* “mouth,” *čix* “ear,” *tolgɔi* “head,” *xoroo* “finger,” *tsarai* “face,”
dal “shoulder,” *bij* “body”

II. *setgel* “thought,” *bɔdɔl* “idea,” *xɔč* “nickname,” *xөг* “shame,” *xusel* “wish”

III. *ɔims* “trousers,” *malgai* “hat,” *šuxer* “umbrella”

IV. *ax* “elder brother,” *exner* “wife,” *xuuxen* “daughter,” *ac ɔxin* “grand daughter”

V. *mər* “horse,” *xɔn'* “sheep”

VI. *uuldberlel* “product”

VII. *and* “sworn friend/best friend,” *naiz* “friend,” *xɔngɔr* “lover,” *ɔbčɔn* “patient,”

professɔrood “professors,” *zaloos* “young people,” *gal komand* “fire chief,”

Jim (psn), *Johncy* (psn), *xob'* “part,” *mər* “footstamp,” *čemɔdan* “suitcase,”

moxlag “wagon,” *boodal* “hotel,” *nɔm* “book,” *gar boo* “pistol,” *dogoi* “wheel,”

mөngө “money,” *adar* “ceiling,” *ɔd* “star,” *som* “village,” *ɔrɔθ* “room,” *ɔr* “bed,”

uj “generation,” *zəbɔlgəθ* “advice,” *Herkimer* (pln), *xɔt* “city,” *zəb* “right,”

tələθ “for ~,” *ar* “behind ~,” *əmnə* “in front of ~,” *end* “here,” *deer* “above”

H': I. *us* “hair,” *gar* “hand,” *tarxi* “brain,” *tolgɔi* “head,” *xəl* “foot,” *belxuus* “waist”

II. *ined* “laughter,” *xarts* “gaze,” *xair* “love,” *oxaan* “wisdom,” *bɔdɔl* “idea,”
oxaan bɔdɔl “idea,” *gansral* “sadness”

III. *xobtsas* “shirt,” *xurem* “jacket,” *žanč* “raincoat”

IV. *gergii* “wife,” *ɔxin* “daughter,” *duu* “younger siblings,” *etseg* “father,”
etseg ex “parents,” *abga* “uncle”

V. *mər* “horse”

VII. *xolgana* “mouse,” *šobooxai* “young bird,” *and* “sworn friend/best friend,”

xɔngɔr “lover,” *xairt* “lover,” *xatagtai* “lady,” *naizood* “friends,”

xɔjool “two persons,” *borxan* “god,” *borxan teŋger* “god,” *bureečid* “trumpetter,”

John (psn), *Della* (psn), *mөngө* “money,” *tootsɔ* “check,” *dərəθ* “rope ladder,”

bosad jum “other things,” *nөгөө xagas* “another one,” *nөгөөx* “another one,”

derged “beside of ~,” *dɔr* “in ~”

DH: I. *ort gezeg* “long hair”

Дээрх жишээнүүдээс үзэхэд буриад хэлтэй адил байж, хамниган монгол хэл шиг *alienable* / *inalienable*-ийг ялгаж байх гэж санагдахгүй. *DH type*-ийн жишээ нь зөвхөн нэг л байсан (10).

(10) *činiü* *namir-san ort gezeg=čin' bur bai-x-gui*

2sg.gen stream-pfv.ptcp long hair=**2sg:poss** perfectly be-fut.ptcp-neg
bol-čix-sən.

become-pfv-pfv.ptcp

“Your streaming long hair has lost.”

Гэвч энэ (10)-дугаар жишээнд хэрэглэгдэх “чинь” бол яг эзэмшигчийг заагаагүй ч байж магадгүй. Хэрвээ жинхэнэ *DH type* орчин цагийн монгол хэлэнд байвал, “миний минь” буюу “манай/бидний маань” гэх мэтийн жишээ ч олдох ёстой. Харин ийм жишээг интернетийн нилээд олон вебсайтуудаас ч олоогүй юм. (2)-дугаар жишээний “чинь”-ийг “маань”-тай сольсон (11)-дүгээр жишээ нь буруу гэж, (12)(13)-дугаар жишээнүүд нь зөв гэж эх хэлтэн үздэг.

(11) Мон. **manai* *ols=maan' bur bajan bol-čix-jee.*

1pl:gen country=**1pl:poss** perfectly rich become-pfv-pst

(12) Мон. *manai* *ols bur bajan bol-čix-jee.*

1pl:gen country perfectly rich become-pfv-pst

“Our country has become rich.”

(13) Мон. *ols=maan' bur bajan bol-čix-jee.*

country=1pl:poss perfectly rich become-pfv-pst

“Our country has become rich.”

Ийм жишээнүүдийг үзвэл, (10)-дугаарын жишээ нь жинхэнэ *DH type* биш гэмээр санагдана. (10)-дугаарын жишээнд ХТЯ-аар л эзэмшигчийг илэрхийлж, хоёрдугаар биед хамаатуулах үг нь зөвхөн өгүүлбэрийн гол гишүүн өгүүлэгдэхүүний илтгэцээр хэрэглэгдэж байгаа биш үү. Орчин цагийн монгол хэлэнд *DH type* алга гэж хэлж болно.

Монгол хэлний (10)-дугаарын жишээнд байгаа “чинь” шиг өгүүлбэрийн гол гишүүн өгүүлэгдэхүүний илтгэцээр хэрэглэх нь хамниган монгол хэл болон буряад хэлэнд ч бас байдаг. Харин энэ хоёр хэлэнд тиймэрхүү гол гишүүн өгүүлэгдэхүүнийг ГБХ үг дагахдаа заавал ХТЯ-ын нэр үгтэй зохицох ёстой. Жишээлбэл, буряад хэлтэй зонууд (14)-дүгээр жишээ нь зөв, (15)-дугаар жишээ нь буруу гэж хариулдаг. Хамниган монгол хэлтэн ч тэгдэг.

(14) Бур. *minii šaarpa-jii=mini хаана tab'-aa=ta.*

1sg:gen scarf-acc=**1sg:poss** where set-ipfv.ptcp=2pl

“Where did you put my scarf?”

(15) Бур. **minii šaarpa-jii=šni хаана tab'-aa=ta.*

1sg:gen scarf-acc=**2sg:poss** where set-ipfv.ptcp=2pl

Хамниган монгол ба буряад хэлэнд (16)-дугаар жишээ шиг өгүүлэхүүн нь хойноо өгүүлэгдэхүүний гурван биеийг хамаатуулах үг авдаг байна. Харин монгол хэлэнд ийм шинж байхгүй. Иймээс зохицолтой (*Хам*, *Бур*) / зохицолгүй (*Мон*) гэдэг ялгаа нь ийм шинжтэй харьцаатай байж магадгүй.

(16) *Хам. bii bagsi=bi. Бур.bii bagša=b'. Мон. bii bagš.*

1sg:nom teacher=**1sg** 1sg:nom teacher=**1sg** 1sg:nom teacher

“I’m a teacher.”

Орчин цагийн монгол хэлний шинжийг хураангуйлбал:

(17) а. *D type*-ийг их хэрэглэдэг. *DH type* байхгүй гэж хэлж болно.

б. ГБХ ёс нь *alienability*-тай харьцаагүй.

3.3 Гурван хэлний хооронд байгаа ялгаа

Одоо хамниган монгол хэл, буряад хэл орчин цагийн монгол хэл гуравны эзэмшигч илрүүлэх аргыг үзье.

Тус тутмын шинжийг товчилбол доорх мэт:

(18)

	<i>Хам</i>	<i>Бур</i>	<i>Мон.</i>
ГБХ, <i>alienability</i> хоорондын харьцаа	Б/на*	Алга	Алга
<i>DH type</i> -ийг хичнээн хэрэглэх	Их>>>>>Үгүй		
ХТЯ, ГБХ хоёрын зохицол	Б/на	Б/на	Алга

*Эзэмшигч нь “хүн” байвал “байна” гэж хэлж болно.

Яагаад хамниган монгол хэлэнд л ГБХ ёс нь *alienability*-тай харьцаатай гэдэг шинжтэй болсон бэ гэвэл, зохиогч миний бие манж-тунгус төрөл хэлнүүдийн нөлөөгөөр ийм болсон гэж бодож байна. Дараа нь эвэнки хэл, хамниган эвэнки хэл хоёрын байдлыг үзье.

4. Эвэнки хэлний эзэмшигч илрүүлэх арга

Сибирийн эвэнкичүүдийн хэрэглэдэг эвэнки хэлээр эзэмшигчийг *DH type*, *H type*, *H' type* гурван янзаар илрүүлнэ. *D type* байхгүй. Эзэмшүүлэгчийг заавал ГБХ дагавар дагадаг. Энэ гурван хэлбэрийн дотор голдуу *H type* хэрэглэгдэнэ гэж Nichols (1986: 68) хэлж байна. Ингэхэд эвэнки хэлний *H' type* нь монгол төрөл хэлнүүдийн

H' type-тай адил биш, *H* type-ын эзэмшигч нэр үг нь орхигдоод ийм болсон гэж хэлж болно.

(19) Эвк.		<i>H</i> type	<i>DH</i> type
<i>tuksaki-l</i>	<i>seer-tin.</i>	<i>Lyuba-ni</i>	<i>girki-n.</i>
<i>hare-pl</i>	ear-3pl:poss	PSN-pssr	friend-3sg:poss
"hare's ear" [Икэгами 1977: 30]		"Lyuba's friend" [Икэгами 1973: 180]	

Эзэмшигчийг дагах дагавар “-*ni*” нь жинхэнэ ХТЯ биш гэж олон судлаачид хэлж байна. Жишээлвэл, ОХУ-ын Nedjalkov (1997: 158) ингэж тайлбарлаж байна.

“The possessive relation maybe expressed by means of the suffix -ngi affixed to the possessor; but this is rare. In this case the possessum has the marker of personal possession.”

Ийм болохоор Nedjalkov (1997: 124) энэ дагаврыг “*unproductive genitive*” (бүтээмжгүй ХТЯ) гэж нэрлэсэн. Бас Японы Икэгами (1999: 346) энэ дагаврыг “*эзэмшилийн тэмдэг нэр буюу эзэмшигчийн төлөөний нэр үгийн дагавар*” гэж хэлж байна.

Үүнийг харахад энэ дагавартай хэрэглэгдэх *DH* type-аас *H*, *H'* type илүү хэрэглэгдэнэ гэж хэлж болно².

Үүнээс гадна, тунгус төрөл хэлнүүд (манж, шибэ, солон хэлнүүдээс бусад) бол монгол төрөл хэлнүүдээс шал ондоо шинжтэй. Тэр нь юу гэвэл “хүний эзэмшилийг бусаддад өгч болно” (*alienable*) гэдгийг илрүүлэх дагаврыг эзэмшүүлэгчид нэмдэг шинж юм. Эвэнки хэлэнд бол, бусдад өгч болох эзэмшүүлэгч нэр үгэнд *-ni-* дагавар дагалдана.

(20) Эвк.	<i>uluki-ni-w.</i>
<i>squirrel-alien-1sg</i>	
"my squirrel (i.e. which I noticed/pursued/killed, etc.)" [Nedjalkov 1997: 145]	

Тунгус төрөл хэлнүүдийн энэ *alienable* дагаврын тухай Японы Казама (2001: 153-154) ингэж хэлж байна: “*Төрөл садан, чиглэл, хувцас хунар, өдөр тутмын хэрэгсэл, юмны нэг хэсэг* (хүний биеийн нэг хэсэг г.м.) *зэрэг нэр үгийг “alienable” дагавар дагадаггүй.*” Үүнээс гадна, Суник (1947: 445) эзэмшигч нь хүн байвал “*alienable*” дагавар дагах боловч, хүнээс бусад эзэмшигч байвал дагахгүй гэж хэлж байна. Чиглэлийг заах нэр үгийг дагадаг гэсэн шинжээс бусад³ нь хамниган монгол хэлний “*alienability*”-ийн шинж (“*inalienable*” байвал ГБХ үг дагаж, “*alienable*” байвал дагахгүй. Харин эзэмшигч нь хүн биш бол иймэрхүү ялгаа байхгүй гэх шинж)-тэй төстэй гэж хэлж болно.

- (21) a. *D* type алга, *DH* type ховор. эжэмшүүлэгч нэр үгэнд заавал ГБХ дагавар дагана.
b. *-ni-* дагаврыг эзэмшүүлэгчид нэмэж “*alienable*” гэдгийг илрүүлнэ.

5. Хамниган эвэнки хэлний эзэмшигч илрүүлэх арга

Хамниган эвэнки хэлээр эзэмшигч илрүүлэх арга нь эвэнки хэлтэй адил биш, яг монгол төрөл хэл шиг *D*, *DH*, *H'* type гурав байна.

(22) ХаЭ.		<i>D</i>		<i>DH</i>	<i>H'</i>
<i>minni</i>	<i>girki-l.</i>	<i>minni</i>	<i>girki-l=bi.</i>	<i>girki-l=bi.</i>	
1sg:gen	friend-pl	1sg:gen	friend-pl=1sg:poss	friend-pl=1sg:poss	
"my friends"		"my friends"		"my friends" [Janhunen 1991: 71]	

Эвэнки хэлнээс ялгаатай зүйл нь *H* type-гүй болж, *D* type (ХТЯ)-тай. *D* type-тай гэдгийг өөрөөр хэлвэл эзэмшүүлэгчид ГБХ үг нэмэхгүй ч болно гэсэн үг юм. Үүнээс гадна, хамниган эвэнки хэлэнд “*alienable*” гэдгийг илрүүлэх дагавар байхгүй гэж Цүмагари (1997: 180-181) илтгэсэн байна. Иймэрхүү 1) ХТЯ-тай, 2) *H* type алга, 3) “*alienable*” дагавар алга гэдэг гурван шинж нь монгол төрөл хэлнүүдтэй харьцаатай, өмнө дэх (Хятад дахь) манж-тунгус төрөл хэлнүүд (манж хэл, солон хэл, шибэ хэл)-д бас байгаа. Манж, солон, шибэ хэлний шинжийн тухай Японы Икэгами (1999) зэрэг эрдэмтэд монгол төрөл хэлнүүдийн нөлөөгөөр үүссэн байх ёстой гэж үзэж байна. Тийм байвал, хамниган эвэнки хэлний энэ шинж ч хамниган монгол хэл буюу бусад монгол төрөл хэлний нөлөөгөөр үүссэн гэж үзэж болно.

Тэгвэл, ХТЯ-тай гэдэг шинж, “*alienable*” дагаваргүй гэдэг шинж хоёрын хооронд ямар нэг харьцаа байгаа юм уу гэвэл үүний тухай манж хэл болон солон хэлэнд ХТЯ-тай болсон нь “*alienable*” дагавар үгүй болсонтой харьцаатай гэж Японы Цүмагари (1992: 277) өгүүлсэн байна. Би бас энэ хоёр шинж нь харьцаатай гэж үзнэ. Nichols (1988: 578) нь *H* type-аар эзэмшүүлэгчийг илрүүлэх хэлэнд заавал “*alienability*”-ийг ялгадаг гэж хэлж байна. Ийм *H* type-ийг нийтлэг хэрэглэдэг Оросын тунгус төрөл хэлнүүд бүр “*alienable*” дагавартай болж түүнээр “*alienability*”-ийг ялгадаг. Харин өмнө дэх (Хятад дахь) тунгус төрөл хэлнүүд бол монгол төрөл хэлнүүдийн нөлөөгөөр ХТЯ-тай болж, ХТЯ-аар “*alienable*”-ийг илэрхийлэх болсон гэж хэлмээр байна.

- (23) a. *H* type алга. ХТЯ-тай. ГБХ дагаврыг нэмэхгүй ч болно.
b. “*alienable*” дагавар хэрэглэгдэхээ больсон.

“А-гийн өмнө” гэх мэт хэлбэр нь “эээмшигч-эээмшиүүлэгч” гэдэг харьцаа биш байгаа учраас “alienable” дагаврыг дагахгүй гэж үзсэн байна.

Нэмзүй

Монгол хэл

Ринчен, Бямбын (1969) *Монгол ард улсын хамниган аялгуу*. [The Khamnigan Dialect in People's Republic of Mongolia] УБ: БНМАУ-ын ШУА-ийн хэвлэл.

Чимэнбат, Бүүбэйн (орч.) (2002) О. Генри *Ид шидтэнүүдийн бэлэг*. [O. Henry *The Gift of the Magi*.] УБ: Өдөр шөнө хэвлэлийн газар.

Орос хэл

Суник, О. П. (1947) “О категории отчуждаемой неотчуждаемой принадлежности в Тунгусо-манжурских языках.” *Известия АН СССР, Отделение литературы и языка*. том 6/вып 5: 437-451.

Англи хэл

Janhunen, Juha (1991) *Material on Manchurian Khamnigan Evenki*. (Castrenianumin toimiteita 40) Helsinki, The Finno-Ugrian society.

---- (1992) “On the Position of Khamnigan Mongol.” *Journal de la Sociëti Finno-Ougrienne*. 84: 115-143.

Nedjalkov, Igor (1997) *Evenki*. London and New York, Routledge.

Nichols, Johanna (1986) “Head-marking and Dependent-marking Grammar.” *Language*. 62(1): 56-119.

---- (1988) “On Alienable and Inalienable Possession.” In: William Shipley (ed.) *In Honor of Mary Haas: From the Haas Festival Conference on Native American Linguistics*. 557-609. Berlin: Mouton de Gruyter.

Tsumagari, Toshiro (1997) “Linguistic Diversity and National Borders of Tungusic.” In: Hiroshi Shoji and Juha Janhunen (eds.) *Northern Minority Languages: Problems of Survival*. (Senri Ethnological Studies 44): 175-186, Osaka, National Museum of Ethnology.

Tsunoda, Tasaku (1995) “The Possession Cline in Japanese and Other Languages.” In: H. Chapell and W. McGregor (eds.) *The Grammar of Inalienability: A Typological Perspective on Body Part Terms and the Part-whole Relation*. 565-630. Berlin and New York: Mouton de Gruyter.

Япон хэл

Икэгами, Жироо (1973) “Сибэриа цүнгүүсү го тэкисүто. 1(Text of the Siberian Tungus language.)” *Хонно бунка кэнкюү*. (*Bulletin of the Institute for the Study of North Eurasian Culture, Hokkaido University*) 6: 163-190.

---- (1977) “Сибэриа цүнгүүсү го тэкисүто. 2(Text of the Siberian Tungus language.)” *Хонно бунка кэнкюү*. (*Bulletin of the Institute for the Study of North Eurasian Culture, Hokkaido University*) 11: 29-37.

---- (1999) “Маншүү го то Цүнгүүсү го: соно коозоожоо но соонтэн то мооко го но ээкёо.” (Manchu and other Tungusic languages: some structural differences and the influence from Mongolian) *Маншүү го кэнкюү*. (*The study of Manchu*) 344-358. Токио: Кюүко шонн.

Казама, Шинжироо (2001) “Цүгүүсү шого ниокэрү жоотоканоо о шимэсү сэцүжи ни цүйтэ.” (On the suffix of alienability in Tungus languages) *Цүмагари, Тошироо* (ред.) *Кан-кита таихээёо но гэнго*. (*Languages of the North Pacific Rim*) 7: 141-156.

Цүмагари, Тошироо (1992) “Шоюү коозоо то жоото каноосэ: Цүнгүүсү го то кинрин но гэнго.” (The possessive structure and alienability in Tungusic and neighbouring languages) *Мияока, Осахито* (ред.) *Кита но гэнго: рүикээ то рэкиши*. (*Languages of the North Pacific Rim: Types and History*): 261-278. Токио: Сансээдоо.

Ямакоши, Ясүхиро (2006) “Шинэхэн бүриято го тэкисүто.” (Shinekhen Buryat Text) *Цүмагари, Тошироо* (ред.) *Кан-кита таихээёо но гэнго*. (*Languages of the North Pacific Rim*) 13: 139-180.

---- (2007a) “Хамүниган монгорү го тэкисүто.” (Khamnigan Mongolian Text) *Цүмагари, Тошироо* (ред.) *Кан-кита таихээёо но гэнго*. (*Languages of the North Pacific Rim*) 14: 145-184.

---- (2007b) “Хамүниган монгорү го.” (Khamnigan Mongolian) *Накаяма, Тошихидэ ба Ямакоши, Ясүхиро*(ред.) *Бүнтоо о какү*. (*Grammatical Sketches from the Field*) 2:229-258.

---- (2010) “Хамүниган эвэнки го то хамүниган монгорү го но шоюү коозоо.” (On possessive NP structure of Khamnigan Evenki and Khamnigan Mongolian) *Күрэбито, Мэгүми* (ред.) *Кан-кита таихээёо но гэнго*. (*Languages of the North Pacific Rim*) 15: 101-116.